



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 12 сарын 02 өдөр

Дугаар А/739

Ховд

62 айлын орон сууцны барилгын гадна фасадны засварын  
ажлыг хүлээн авах ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2-ын "б", Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрмийн 1 дүгээр хавсралтын 2, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар "Динатос" ХХК-ийн хийж гүйцэтгэсэн 62 айлын орон сууцны барилгын гадна фасадны засварын ажлыг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн

ахлагч: Б.Туулайтулга - Жаргалант сумын Засаг даргын орлогч

Гишүүд: Д.Нямтулга - Мэргэжлийн хяналтын газрын барилгын техникийн хяналтын улсын байцаагч

Б.Түмэндэмбэрэл - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн

З.Өмиртай - Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга

Г.Баатарболд - Хөндлөнгийн орон тооны бус ажлын хэсгийн гишүүн

Ц. Бэхбаяр - Магсаржав багийн Нийгмийн ажилтан

Ц.Цолмонбаатар - Стандарт, хэмжил зүйн хэлтсийн салбар сан хариуцсан мэргэжилтэн

Ц.Даваасамбуу - Орон нутгийн өмчийн газрын ахлах мэргэжилтэн

С.Батдорж - Аймгийн Архивын тасгийн дарга

Ц.Баяржаргал - "Динатос" ХХК-ийн захирал

Нарийн бичгийн  
дарга: Б.Жамбалдорж - Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын  
газрын мэргэжилтэн

2. “Динатос” ХХК-ийн хийж гүйцэтгэсэн ажлыг захиалагчаас өгөгдсөн ажлын тоо хэмжээтэй тулган шалгаж, өмч бүртгэлд тусгаж хүлээн авах эсэх талаар шийдвэр гарган танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч /Б.Туулайтулга/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН  
ОРЛОГЧ



Т.ЖАРГАЛСАЙХАН